## МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

| № | Зорилт /бодлогын үндэслэл/ | Төсөл, арга хэмжээ | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт | | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Зорилтот түвшин | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **БҮЛЭГ 2.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | |
| **Зорилго 2.1.Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.** | | | | | | |
| 2.1.12 | МУТЖҮЧ-2.2.5, ЗГҮАХ -2.1.7 | Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн хамрагдалтыг нэмэгдүүлэх | Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн хамрагдалт 94.2 хувьтай байна. | Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн хамрагдалт 95 хувьд хүрсэн байна. | Сумын нийгмийн даатгалын байцаагчтай хамтран ард иргэдийг эрүүл мэндийн даатгалд хамруулах талаар сургалт сурталчилгааг 3 удаа зохион байгуулсан. Эмнэлэгт эмнэлгийн тусламж үйлчилгээ авахаар ирсэн иргэдэд даатгалд хамрагдахын ач холбогдлын талаар яриа таниулгыг тогтмол хийж байна. Даатгалд хамрагдадлтын хувь 80%-тай байна. | 50 |
| 2.1.13 | МУТЖҮЧ-2.2.5, ЗГҮАХ -2.1.7 | Олон улсын эмнэлзүйн удирдамжийн цахим санг нэвтрүүлэх | Цахим санг нэвтрүүлэх гэрээг олон улсын байгууллагатай байгуулсан. | Олон улсын эмнэлзүйн удирдамжийг эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлсэн байна. | 15 өвчний эмчилгээ оношлогооны эмнэлзүйн заавраар гарын авлага бэлтгэж, эмч бүрийн гарт ойрхон байлгаж, эмчилгээ оношлогоондоо ашиглаж байна. | 50 |
| 2.1.14 | МУТЖҮЧ-2.2.7, ЗГҮАХ -2.1.8 | Эм ханган нийлүүлэх байгууллагуудад эмийн аюулгүй байдлын цахим | Төлөвлөлтийн шатанд байна. | Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл, хяналтад эм ханган нийлүүлэх | Эмийн сан нь магадлан итгэмжлэгдсэн Эм ханган нийлүүлэх байгууллагатай гэрээ байгуулан, аюулгүй, | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | бүртгэл, хяналтын нэгдсэн программ хангамж нэвтрүүлэх | | байгууллага 100 хувь хамрагдсан байна. | чанартай эм тариаг татан авч, ард иргэдэд үйлчилж байна. | |
| 2.1.18 | МУТЖҮЧ-2.2, ЗГҮАХ-2.1.13 | Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний багцыг оновчтой болгож, гүйцэтгэлийн шалгуурын дагуу тусламж, үйлчилгээ, иргэнийг дагасан гүйцэтгэлийн санхүүжилтийг нэвтрүүлэх | 4 багцыг тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдсэн. | Бүх өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд нэвтрүүлж эхэлнэ. | Эрүүл мэндийн даатгалын сангаас 4 төрлийн тусламж үйлчилгээг санхүүжилж байна. Үүнд: 2022 оны эхний 5 сарын байдлаар<br>➢ өдрийн эмчилгээнд-89<br>➢ гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээнд-18<br>➢ сэргээн засах тусламж үйлчилгээнд-216<br>оношилгоо шинжилгээнд-487 хүнийг тус тус хамруулж, 13852490 төгрөгний санхүүжилт авсан байна. | 50 |
| 2.1.19 | МУТЖҮЧ-2.2.2, ЗГҮАХ -2.1.1 | “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг хэрэгжүүлэх | Төлөвлөлтийн шатанд байна. | Арга хэмжээний хэрэгжилт 40 хувьд хүрсэн байна. | "Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээг 2021 -2024 оны хугацаанд хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө боловсруулан ЭМТ-ийн даргаар батлуулан хэрэгжүүлж ажиллаж байна. Төвөлгөөнд нийт 18 үйл ажиллагаа төлөвлөсөн. Хагас жилийн байдлаар нийт 50% гүйцэтгэлтэй явж байна.<br>Эхчүүд, эмэгтэйчүүдийн эрх ашгийг хамгаалах, манлайллыг түгээх орон нутаг дахь эмэгтэйчүүдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, орон нутгийн | 50 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | удирдлага төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран уялдаа холбоог сайжруулах үүднээс Цагааннуур сумын эмэгтэйчүүдийн холбоотой хамтран Эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг 2022.03.06-нд зохион байгуулсан. Уулзалтанд Гэр бүлийн үнэ цэнэ сэдэвт лекторын лекц тавьж, 10 эмэгтэйчүүдийг сумаас шагнах үйл ажиллагаа явуулсан.Уулзалтанд нийт 156 эмэгтэйчүүд оролцсон | |
| 2.1. 20 | МУТЖҮЧ-2.2.2, ЗГҮАХ-2.1.1 | “Хавдрын эсрэг” арга хэмжээг эхлүүлж, хүн амын дунд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ зохион байгуулах | Төлөвлөлтийн шатанд байна. | Хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгийн хамралтын түвшин 30 хувьд хүрсэн байна. | Дэлхийн хавдрын эсрэг өдрийг угтаж 2022 оны 02 сарын 04-ний өдөр 2 удагийн сургалт зохион байгуулж 85 хүний хамруулж 134 сургалтын материал тараасан | 50 |
| 2.1. 21 | МУТЖҮЧ-2.2.2, ЗГҮАХ -2.1.1 | “Элэг бүтэн Монгол” арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, элэгний делта вирустэй иргэдийг эмчилгээнд хамруулах | Төлөвлөлтийн шатанд байна. | Арга хэмжээний хэрэгжилт 30 хувьд хүрсэн байна. | Элэг бүтэн Монгол арга хэмжээний хүрээнд сумын зорилтод 40-65 насны иргэдийн Элэгний хорт хавдар эрт илрүүлгийн үзлэг явуулж байгаа бөгөөд хагас жилийн байдлаар 182 хүнийг хамруулж 12 иргэнийг дээд шатлал руу оношлогоонд явуулж 1 илэрч, хяналтанд авсан | 50 |
| 2.1. 22 | МУТЖҮЧ-2.2.2, ЗГҮАХ -2.1.1 | “Харшлаас сэргийлэх” арга хэмжээг хэрэгжүүлэх | Төлөвлөлтийн шатанд байна. | Арга хэмжээний хэрэгжилт 70 хувьд хүрсэн байна. | “Харшлаас сэргийлэх” арга хэмжээг 2021 -2024 оны хугацаанд хэрэгжүүлэх дунд | 30 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хугацааны төлөвлөгөө боловсруулан ЭМТ-ийн даргаар батлуулан хэрэгжүүлж ажиллаж байна. Энэ оны хагас жилийн байдлаар иргэдийн дунд Харшил гэж юу вэ? сэдэвт 2 удаагийн сургалтаар 62 хүнийг хамруулж, 125 ширхэг гарын авлага тарааж ажилласан. Эмнэлэгт харшил үүсгэх эд хогшил байгаа эсэхэд хяналт тавьж ажилласан. | |
| 2.1. 23 | ЗГҮАХ-2.1.4 | Лавлагаа шатлалын 11 эрүүл мэндийн байгууллагын яаралтай тусламжийн чадавхыг сайжруулж, техник, тоног төхөөрөмжөөр хангах | Чадавх бэхжүүлэх зорилгоор эрүүл мэндийн байгууллагуудад нийлүүлэх шаардлагатай тоног төхөөрөмжийн тооцоо, судалгаа бүрэн хийгдсэн. | Лавлагаа шатлалын 11 эрүүл мэндийн байгууллагын яаралтай тусламжийн чадавх бэхжсэн байна. | Яаралтай тусламжийн нэгжид шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг хангаж, ашиглаж байна. 2022 оны хагас жилийн байдлаар яаралтай тусламжийг 12 хүнд үзүүлсэн байна. Яаралтай тусламжийн эрэмбэлэн ангилалтын самбарыг шинэчилж, яаралтай тусламжийн өрөөнд байрлуулсан. | 70 |
| 2.1. 24 | МУТЖҮЧ-2.2.5, ЗГҮАХ -2.1.7 | Эрүүл мэндийн даатгалыг цахимжуулах | Эрүүл мэндийн байгууллагуудад e-health, h-info, health.gov.mn программуудыг ашиглаж байна. | Эрүүл мэндийн даатгалын цахим тогтолцоог бий болгож, бүх шатны эрүүл мэндийн байгууллагыг холбоно. | Эрүүл мэндийн төв нь h-info, health.gov.mn программуудыг ашиглаж, тусламж үйлчилгээгээ явуулж байна. | 70 |
| 2.1. 26 | ЗГҮАХ-2.1.9 | Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх | - | Хөтөлбөрийн хэрэгжилт 70 хувьд хүрсэн байна. | - **“Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгаалал**” хөтөлбөрийн хүрээнд Ажилчдад амралтын цайны цагаар | 50 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хооллох боломжтой хоолны заалыг гаргаж тохижуулсан. Тохижилтон / ширээ, сандал, хөргөгч, ус буцалгагч, цахилгаан зуух/ зэрэг тоног төхөөрөмжүүдийг байрүүулсан. Мөн хоолны мөнгө төлж хоол авч идэх боломжтой нөхцөлөөр хангаж, амралтын үеэр кофе, цай уух нөхцөлөөр хангасан. Нийт ажилчдын сэтгэл ханамж 100% байсан.<br>- Нийт 24 эмч, ажилчид эмчийн үзлэгт хамрагдсанаас 17 буюу 70,8% нь хууч өвчлөлтэй илэрч, 7 буюу 29,1% нь эрүүл гарсан байна. Өвчлөлтэй ирсэн ажилчдад дээд шатлалын эмнэлэгт онош тодруулах цалинтай чөлөө 3 ажилчинд өгч, 5 ажилчинг өдрийн эмчилгээнд хамруулж, 2 ажилтан хэвтэн эмчлүүлж, 3 эмийн бус эмчилгээнд хамрагдан арга хэмжээ авч ажилласан.<br><br>Сувилагч нарт зориулсан амралтын болон ажлын өрөөг тусад гаргаж өгч, ээлжинд хоноож байгаа сувилагч тухтай амрах | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | боломжттой нөхцөлийг бүрдүүлж өгсөн. | |
| 2.1.31 | МУТЖҮЧ-2.2.3, ЗГҮАХ-2.1.12 | Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийн засвар шинэчлэлтийн ажлыг хийх | Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн хүрээнд хэрэгжсэн. | Тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ. | ЭМТ-ийн цэвэр, бохир усны сантехникийн засварын ажил хийгдэж байна. | 30 |
| **Зорилго 2.2.Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.** | | | | | | |
| 2.3.1 | МУТЖҮЧ-2.1.8, ЗГҮАХ-2.3.9 | Төр-хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хөдөөгийн 113 цэцэрлэг, 176 сургууль, 121 дотуур байрыг шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангах | Санхүүжилт шийдвэрлэгдсэн. | 113 цэцэрлэг, 176 сургууль, 121 дотуур байр төвлөрсөн болон бие даасан ариун цэврийн байгууламжтай болсон байна. | Сургууль, дотуур байр, цэцэрлэгүүд төвлөрсөн ариун цэврийн байгууламжтай. | 100 |
| 2.3.2 | МУТЖҮЧ-2.1.1, ЗГҮАХ-2.3.2 | Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, 50 гэр бүлэг байгуулж, хувилбарт сургалтад 500 хүүхэд нэмж хамруулах;<br>24 цагийн 10 бүлэг нээж 250 хүүхдийг шинээр хамруулах | Хувилбарт сургалтад 17141 хүүхэд хамрагдсан.<br>32 цэцэрлэгийн 24 цагийн 77 бүлэгт 2226 хүүхэд хамрагдсан.<br>Нийт хамран сургалт 93.4 хувьтай байна. | Шинээр 50 гэр бүлэг байгуулж, хувилбарт сургалтад 500 хүүхэд,<br>24 цагийн 10 бүлэг шинээр нээж 250 хүүхэд нэмж хамруулсан байна.<br>Хамран сургалтыг 95 хувьд хүргэсэн байна. | Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж 1-р цэцэрлэг 1, 2-р цэцэрлэг 2 гэр бүлэг байгуулж, хувилбарт сургалтад 85 хүүхэд хамруулж байна. | 100 |
| 2.3.3 | МУТЖҮЧ-2.1.2, ЗГҮАХ-2.3.3 | Бага, дунд боловсролын чанарын болон суралцагчийн сургалтын ахиц, дэвшлийн үнэлгээг тогтмол хийж, хоцрогдлыг арилгах цогц төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах | Бага ангид суралцагчдын унших чадварын түвшин 37.5 хувь,<br>бичих чадварын түвшин 37.5 хувь,<br>математик чадварын түвшин 53.3 хувь,<br>дунд ангийн суралцагчдын ерөнхий чадварын түвшин 37.5 хувь, | Суралцагчдын сурлагын амжилтын өсөлт 10 хувь болсон байна.<br>Бага ангийн суралцагчдын унших, бичих, математик чадварын, дунд ангийн суралцагчдын ерөнхий чадварын, ахлах ангийн суралцагчдын сонгон судалсан хичээлийн эзэмшилтийн түвшин өмнөх онтой харьцуулбал тус тус 5-10 хувиар өссөн байна. | Хичээлийн жилийн эхэнд БШУСайдын баталсан 280-р тушаалын дагуу хүүхдийн суурь үнэлгээг хийж хичээлийн жилийн эцэст хөгжлийн ахицыг үнэлэн гаргасан. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | ахлах ангийн суралцагчдын сонгон судалсан хичээлийн эзэмшилтийн түвшин 31.9 хувь байна. | | | |
| 2.3.5 | МУТЖҮЧ-2.1.3, ЗГҮАХ -2.3.4 | Эх хэлний сургалтын чанарыг дээшлүүлж, монгол бичгийн сургалт, судалгаа, хэрэглээний орчныг сайжруулах | Монгол хэл, бичгийн сургалтын чанарын үнэлгээг зохион байгуулах бэлтгэл ажлыг хийсэн. | Монгол хэл, бичгийн сургалтын чанарын үнэлгээнд дунд, ахлах анги төгсөгчдийг хамруулсан байна. Монгол бичгийн хэвлэмэл болон цахим сурах бичиг, гарын авлагыг боловсруулж, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангасан байна. | 2020-2021 оны хичээлийн жилд сумын ЕБСБДС-н монгол хэлний секцтэй хамтран ажиллаж нийт багш нарт 30 цагийн монгол бичгийн хичээл сургалтыг амжилттай зохион явуулсан. Ерөнхий боловсролын сургууль Монгол бичиг-2022 өдөрлөг зохион байгуулж 3 төрлийн арга хэмжээнд 57 иргэн хамрагдсан. | 70 |
| 2.3.7 | МУТЖҮЧ-2.1.3, ЗГҮАХ -2.3.4 | Хүүхдийн ялгаатай онцлог, суралцах чадамжид суурилан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгох | Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд тэгш хамруулах журам батлагдсан. Хэрэгжилт 25 хувьтай байна. | Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн онцлог, суралцах чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулж, багш нарыг арга зүйгээр хангаж хэрэгжүүлсэн байна. Хэрэгжилт 100 хувьд хүрсэн байна. | Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн онцлог, суралцах чадамжид суурилсан хөтөлбөр боловсруулан тойргын 6 хүүхдээс 2 хүүхдийг нь СӨБ-д хамруулсан бөгөөд ганцаарчилсан хөтөлбөр хэрэгжүүлсэн. | 70 |
| 2.3.8 | МУТЖҮЧ-2.1.7, ЗГҮАХ -2.3.8 | Багш мэргэжлийн стандартыг батлуулж, “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлэх | -Багш бэлтгэх их, дээд сургууль болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, судлаачдын хамтарсан судалгаанд санхүүжилт олгохоор судалж эхэлсэн. | -Багш бэлтгэх их, дээд сургууль болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, судлаачдын хамтарсан судалгаанд санхүүжилт олгосон байна.<br>-10 аймаг, 5 дүүргийн ерөнхий боловсролын | Багш нар ажлын байран дахь сургалтыг 7 хоног бүрийн ЗАН-н ажлаар тодорхой сэдвийн хүрээнд зохион байгуулж ирсэн төдийгүй багш нар цахим орчин буюу fasebook –ээс мэргэжлийн багш нарын бэлтгэсэн цахим сургалтуудаас суралцаж өөрийн үйл ажиллагаандаа | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | -Монтёр багштай сургууль, цэцэрлэгийн тоо-0;<br>-Монтёр багштай хамтран хөгжиж байгаа багшийн хувь-0;<br>-Багшийн ажлын гүйцэтгэлд суурилсан цалин хөлсний тогтолцоо бүрдээгүй. | сургууль ментор багштай болсон байна.<br>-Нийт багш нарын 44.7 хувь ментор багштай хамтран хөгжих боломж бүрдсэн байна.<br>-Гүйцэтгэлд суурилсан цалин хөлсний хууль, эрх зүйн орчин бүрдсэн байна. | нутагшуулах чадвар эзэмшиж Kinemaster , Video Maker , VCUT зэрэг апликейшн ашиглан сургалт үйл ажиллгааны чанарыг нэмэгдүүлж сонирхолтой хэлбэрээр хүүхдэд хүргэж байна.<br>Сургалтын хөтөлбөрийн агуулгыг хүүхдэд хүргэх үйл ажиллагаагаа улам чанаржуулах, багшийн чадварыг сайжруулахын тулд өөрийн цэцэрлэгийн багш ,туслах багш нарын дунд нээлттэй хичээл үйл ажиллагааг сар бүр амжилттай зохион байгуулж дотоодын нөөц бололцоог ашиглан туршлагаа солилцлоо.<br>-БМДИ-ийн эхний жилийн мэргэшүүлэх сургалтад эхний жилдээ ажиллаж байгаа 2 багийг хамруулсан. Ажлын байрандаа 8 удаагын сургалтад давхардсан тоогоор 45 багш хамрагдсан. | |
| 2.3. 9 | МУТЖҮЧ-2.1.7, ЗГҮАХ -2.3.8 | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийг ялгаатай хэрэгцээт боловсролын чиглэлээр мэргэшүүлж, цэцэрлэгт ээлжийн багш ажиллуулах | Ерөнхий боловсролын сургууль дээр байгуулагдсан “Хүүхэд хөгжлийн загвар танхим”-д ажиллах багш, удирдах ажилтнуудыг чадавхжуулах сургалтад 100, | -Ерөнхий боловсролын сургуулийн 165, цэцэрлэгийн 230 багшийг мэргэшүүлсэн байна.<br><br>-Цэцэрлэгт ээлжийн 200 багш ажиллуулсан байна. | 2-р цэцэрлэгийн 1 багш цахимаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй” сэдэвт 32 цагийн сургалтад хамрагдсан.<br>Ээлжийн багш ажиллах шийдвэр ирээгүй тул хэрэгжээгүй болно | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад чадавхжуулах” сургалтад 100, нийт 200 багшийг мэргэшүүлсэн. | | | |
| 2.3. 13 | МУТЖҮЧ-2.1.10, ЗГҮАХ-2.3.12 | Боловсролын цахим шилжилтийн хүрээнд боловсролын салбарын мэдээллийн систем, тоног төхөөрөмж, дэд бүтцийг үе шаттайгаар сайжруулж, цахим сургалтын нэгдсэн платформыг хөгжүүлэх | -Багшийн үндсэн сургалтыг цахим хэлбэрт шилжүүлж, сургалтын платформын хөгжүүлэлт 50 хувьтай байна.<br>-Боловсролын нэгдсэн сүлжээнд төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 60 хувь холбогдсон.<br>-Цахим сургалтын нэгдсэн платформд теле хичээл, интерактив контент, сурах бичиг зэрэг 3900 гаруй контент байршуулсан. | -Багшийн үндсэн сургалтыг цахим хэлбэрт шилжүүлсэн байна. Нийт ерөнхий боловсролын сургуулийг боловсролын салбарын нэгдсэн сүлжээнд холбож, өндөр хурдны интернэт үйлчилгээ үзүүлдэг болсон байна.<br>-Төрийн өмчийн цахим сургууль байгуулж, гадаад улсад амьдарч байгаа иргэдийн хүүхдэд ерөнхий боловсрол эзэмшүүлнэ.<br>-Цахим ээлжит хичээлийн 10000 контент бэлтгэсэн байна.<br>-Төрийн өмчийн 500 цэцэрлэг интернэтэд холбогдсон байна.<br>-Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох цахим агуулга баяжсан байна. | 1-р цэцэрлэг багшийн хэрэгцээнд зориулан багш хөгжлийн төвд өнгөт принтер -2 , 3 үйлдэлт принтер -1, суурин компьютр-2, зөөврийн компьютр 8 ашиглаж байна. МИКОМ компаний шилэн кабелд холбогдсон интернэтээс мэдээлэл авах бүрэн боломжтой. | 70 |
| 2.3. 16 | МУТЖҮЧ-2.1.9, ЗГҮАХ-2.3.10 | Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдыг сургууль дээр ундны ус уух боломжийг бүрдүүлэх | Нийт сургуулийн 30 хувьд ус цэвэршүүлэгч төхөөрөмж суурилуулсан. | Нийт сургуулийн 50 хувьд ус цэвэршүүлэгч төхөөрөмж суурилуулсан байна. | Сургууль, цэцэрлэгүүд гал тогоондоо ундны усанд цэвэршүүлэгч төхөөрөмж суурилуулсан бөгөөд бүлгийн хүүхэд бүр ус уух боломжоор бүрэн хангагдсан. | 100 |
| 2.3. 18 | МУТЖҮЧ-2.1.9, | Цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг нэмэгдүүлж, өдөрт авбал | Нөхцөл байдлын судалгааг хийж, судалгааны үр дүнгээр | Хүүхдийн нас, биеийн онцлогт тохирсон шим тэжээллэг хоол хүнсээр | Хүүхдийн хувьсах зардлаар олгогддог санхүүжилтийн дагуу өдөр бүр хүүхдэд амт | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | ЗГҮАХ-2.3.10 | зохих илчлэг, шим тэжээлийн хэрэгцээг хангахуйц хоолоор үйлчлэх | хүүхдийн хоолны зардлын нормативыг үе шаттайгаар нэмэгдүүлэх тооцоог хийсэн. Цэцэрлэгийн 247040 хүүхэд, дотуур байрны 35000 хүүхэд хамрагдсан. | үйлчлэх боломж бүрдсэн байна. Цэцэрлэгийн 289144 хүүхэд, дотуур байрны 38000 хүүхэд хамрагдсан байна. | илчлэг сайтай хүрэлцээтэй хоолоор үйлчилж ирсэн. Жил бүр хүүхдийн өдөр тутмын хоолны нээлттэй амталгаат өдөрлөгийг зохион байгуулж эцэг эхэд үйл ажиллагаагаа суртчилдаг. Мөн Боловсролын мэдээллийн системд хүүхдийн өдөр бүр идсэн хоол түүний илчлэг норм зэргийг байршуулж байна. | |
| 2.3.19 | МУТЖҮЧ-2.1.9, ЗГҮАХ-2.3.10 | Ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд ангийн суралцагчдыг үдийн хоолны үйлчилгээнд хамруулах, нэг хүүхдэд ногдох хоолны зардлын нормативыг шинэчлэх, мэргэжлийн хүний нөөцөөр хангах | Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн суралцагчдад үдийн цайны үйлчилгээг хүргэж байна. | 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн суралцагчдыг, 2022-2023 оны хичээлийн жилээс дунд ангийн суралцагчдыг үдийн хоолны үйлчилгээнд бүрэн хамруулсан байна. | Бага ангийн 558 сурагч үдийн хоолны үйлчилгээ авч байна. | 100 |
| **Зорилго 2.5.Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ.** | | | | | | |
| 2.5.1 | ЗГҮАХ-2.5.1 | Нийгмийн даатгалын эрх зүйн орчныг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжүүлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх | Нийгмийн даатгалын эрх зүйн шинэчлэл хийгдээгүй, олон давхаргат тэтгэврийн тогтолцоо бүрдээгүй байна. | Нийгмийн даатгалын багц хууль батлагдсан байна. | 2022 оны эхний хагас жилд шинээр өндөр насны тэтгэвэр 20, тахир дутуугийн тэтгэвэр 13, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 2 иргэний материалыг хүлээн авч аймгийн НДХэлтэст хүргүүлэн тэгтгэвэр тогтоолгосон. 2022.01.01-ээс Нийгмийн даатгалын хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан мөн 2022 оны 2 дугаар 01-ээс тэтгэвэр авагчдын тэтгэврийн | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэмжээг 15 хувиар нэмэгдүүлсэнтэй холбоотой сар бүр хууль журмын дагуу хугацаанд олгож иргэдэд чирэгдэлгүй үйлчилсэн байна. | |
| 2.5. 8 | МУТЖҮЧ-3.3, ЗГҮАХ-2.5.9 | Орлого багатай өрхийн гишүүдийг мэргэжлийн ур чадвар олгох, мэргэшүүлэх, хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулж, ажилд зуучлах, онцлог хэрэгцээнд нийцүүлсэн арга хэмжээ, төсөл хэрэгжүүлэх | Мэргэжлийн ур чадвар олгох тусгайлсан төсөл, арга хэмжээ байхгүй. | Мэргэжлийн ур чадвар олгох сургалтад 3000 хүнийг хамруулж, 80-аас доошгүй хувийг ажилд зуучилсан байна. | 2022.06.08-нд Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдданг 35 иргэнг “Харилцаа хандлага” сургалтанд хамруулсан. | 50 |
| 2.5. 10 | ЗГҮАХ-2.5.6 | Нийгмийн халамжийн арга хэмжээг нээлттэй, ил тод, олон нийтийн хяналттай, үр дүнтэй, хүнд сурталгүй, албан тушаалтнуудын оролцоогүй болгох зорилгоор цахим хэлбэрт шилжүүлэх | Нийгмийн халамжийн үйлчилгээний 15 хувь цахимжсан байна. | Нийгмийн халамжийн үйлчилгээний 60 хувь цахимжсан байна. | Ехаламж-ийн системд шилжиж байна. | 50 |
| 2.5. 12 | ЗГҮАХ-2.5.6 | Хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг бууруулж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх | -Ядуурлын түвшин 28.4 хувь /2018 он/<br><br>-Хөдөлмөр, эрхлэлтийн түвшин 52.7 хувь /2020 оны 4 дүгээр улирал/ | Ядуурлын түвшин буурч, өрхийн орлого нэмэгдсэн байна. | **Нийтийг хамарсан ажил**<br>1.”Ногоон байгууламжын хашаа барих” төслөөр ажил идвэхтэй хайгч 10 ажилгүй иргэнийг 7 хоногийн хугацаанд түр ажлын байраар хангаж 2520.0 мянган төгрөгийн хөлсийг олгосон.<br>2. “Ногоон ажлын байр хөтөлбөрийн хүрээнд ногоон мод тарих” төслөөр ажилгүй 10 иргэнд 5 хоногийн хугацаатай түр ажлын байр | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бий болгож 1800.0 мянган төгрөгийг олгосон. | |
| 2.5.14 | ЗГҮАХ-2.5.7 | Нийгмийн халамжийн бодлогын шинэчлэлийг хийж, зорилтот өрх, иргэнийг тодорхойлох аргачлалыг сайжруулах | Аргачлалыг 2016 онд баталсан. | Өрхийн амьжиргааны түвшнийг тодорхойлох шинэчлэн баталсан аргачлалд үндэслэн 2022 онд өрхийн амьжиргааны түвшнийг тодорхойлох судалгааг нийт өрхийн 30 хувийг хамруулан зохион байгуулна. | ӨАТТСудалгаанд 5 өрхийн 25 иргэний хамруулаад байна. Улсын хэмжээний эгдсэн судалгаа явагдаагүй байгаа. | 30 |
| 2.6.5 | МУТЖҮЧ-1.1.4, ЗГҮАХ -2.6.3 | Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулж хамгаалуулах | Засгийн газрын 2020 оны 13 дугаар тогтоолоор 187 дурсгалыг улсын хамгаалалтын жагсаалтад оруулсан. | Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын 50 хувийг гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдээр хамгаалуулна. | Сумын бүртгэл мэдээллийн санд нийтдээ 153 түүх соёлын үл хөдлөх дурсгал бүртгэлтэй байдаг. 2022 оны эхний хагас жилийн байдлаар 3 удаа Цагааннуур Сум Соёлын Төв фэйсбүүк цахим хаягаар сурталчиллаа. 2022 онд 17 иргэн аж ахуй нэгж байгууллагтай гэрээгээ шинэчлэн байгуулах ажил эхэлж байна. | 70 |
| 2.6.6 | МУТЖҮЧ-1.1.4, ЗГҮА Х-2.6.3 | Баримтат өвийн бүртгэлийн нэгдсэн системийн үйл ажиллагааг шинэчилж, иргэн, сүм, хийдийн өмчлөл, эзэмшилд байгаа 1000 баримтат өвийн бүртгэлийг хийх | Баримтат өвийн бүртгэлийн нэгдсэн системд бүртгэл хийгдээгүй байна. | Иргэдийн гар дээрх 1000 баримтат өвийг бүртгэн баримтжуулсан байна. | 2022 оны 1-р сард сумын соёлын биет бус өвлөн уламжлагч Доржсүрэнгийн туульс хайлах өвийг видеожуулж баримтжуулан бүртгэн авсан. | 50 |
| 2.6.7 | МУТЖҮЧ-1.1.2, 1.2.1, ЗГҮАХ -2.6.4 | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх “Соёлын бүтээлч үйлдвэрлэл-II”, “Монгол соёл, Монголын баялаг” цогц арга хэмжээг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих нөхцөл бүрдээгүй. | -“ISO Research Standard-20252” стандартад нийцүүлэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын чанарын судалгааг хийж гүйцэтгэсэн байна. | Суманд бүртгэлтэй соёлын биет бус өвлөн улажмлагчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид соёл олон нїтийн арга хэмжээний өдрүүдэд бүтээлийн үзэсэлэн худалдаа, үзэсгэлэнг | 50 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | -Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын хөгжлийн загвар, зураглал, экосистемийн суурь загвар, салбарын хамрах хүрээ, тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон байна.<br>-Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор болон академи байгуулах техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн байна. | гаргасан. Нийт 6 иргэн бүтээл гаргасан. Мөн иргэдийн дунд бүтээлийн уралдаан зарлаж 1,2,3,-р байр шалгаруулж урамшуулсан. | |
| **БҮЛЭГ 3.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** | | | | | | |
| **Зорилго 3.3.Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.** | | | | | | |
| 3.3. 9 | ЗГҮАХ-3.3.4 | Үржлийн хээлтүүлэгч, цөм сүргийн хээлтэгч, Төвийн бүсийн үхэр сүргийг ялган тэмдэглэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх | Нийт 32.0 сая толгой мал бүртгэлд хамруулахаас 3.0 сая толгой /9.3 хувь/ бүртгэлд хамрагдсан. | Үржлийн хээлтүүлэгч, цөм сүргийн хээлтэгч, Төвийн бүсийн үхэр сүргийн 6.6 сая толгой /20.5 хувь/ малыг ялган тэмдэглэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлсэн байна. | Газар тариалангийн бүсэд үржүүлж буй мал сүрэгт үзлэг ангилалт хийх, ашиг шимийн үзүүлэлтийг тогтоох, цөм сүрэг бүрдүүлэх, баталгаажуулах, ээмэгжүүлэх, бүртгэлжүүлэх ажлын 1-р багцад хамрагдсан Сэлэнгэ аймгийн Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн сумдад “Хуурч сүрэг” хоршооны ангилалт, үзлэгийн баг шинжээч мал зүйч 1, ангиалагч мал зүйч 2, бүртгэлийн ажилтан 2, мал баригч 2, нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй, сумдын Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсгийн гишүүдтэй хамтран 05-р сарын 02-ноос 17 хоног ажилласан. Үйл | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажлллагааны хүрээнд 89 өрхийн 242 адуу, 3628 үхэр, 15414 хонь, 7860 ямаа, нийт 24432 малд үзлэг хийж, 39 адуу, 1972 үхэр, 1371 хонь, 490 ямаа, нийт 3872 малын үндсэн үзүүлэлтүүд болох сэрвээ, хондлойн өндөр, биеийн ташуу урт, шилбэний бүслүүр, бүсэлхийн тойрог, цээжний гүн, өргөн, амьдын жингийн хэмжээг авч, ялган тэмдэглэгээ хийн, “Мал аж ахуйн нэгдсэн систем”-д шивэн баталгаажуулсан. | |
| 3.3.11 | МУТЖҮЧ-8.3.10, ЗГҮАХ-3.3.7, 3.3.12 | Цахим хөдөө аж ахуй, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг байгуулж, Хөдөө аж ахуйн биржийн шинэчлэлийг хийж, хоршооны бүтцэд тулгуурлан бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг боловсронгуй болгон загвар хоршоодыг байгуулах | Загвар хоршоо байхгүй. | Загвар 10 хоршоотой болсон байна. | Хоршоог дэмжих, загвар хоршоотой болох талаас төрөөс болон орон нутгаас дэмжлэг үзүүлэж байгаа үнээс хөнгөлттэй зээл олгон загвар хоршоотой болгох талаар хоршоодыг сургалтанд хамруулж дэмжлэн бэлтгэж байна. | 50 |
| 3.3.12 | МУТЖҮЧ-8.3.15, ЗГҮАХ-3.3.13 | Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, ажлын байр бий болгох, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих зээл, санхүүжилтийн бодлого хэрэгжүүлэх | Шинээр 3000 ажлын байр бий болгосон. | Шинээр нэмж 2000 ажлын байр бий болсон байна. | Шинээр ажлын байр бий болох талаар хоршоо хөгжүүлэх сангийн зээл зарлагдсан байна. Хоршоодуудыг ажиллах хүчин чадалаа нэмэгдүүлэн ажлын байрыг бий болгох тал дээд анхаарч байна. | 50 |
| 3.3.13 | ЗГҮАХ-3.3.13 | Жижиг, дунд үйлдвэрийн бизнес эрхлэгчдэд орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлэх. | Жижиг, дунд үйлдвэрийн газрыг байгуулсан. | Орон нутгийн нэгдсэн бүтцийг бий болгоно. | Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн шинэчилсэн судалгаа гаргаж байна. | 50 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг төрөөс бизнес инкубацын үйлчилгээгээр бойжуулах, томруулах бодлогыг боловсронгуй болгох | | | | |
| **Зорилго 3.6.Эдийн засгийн өсөлтийг хангахуйц, тээврийн ухаалаг системд суурилсан үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулна.** | | | | | | |
| 3.6. 21 | МУТЖҮЧ-8.1.1, ЗГҮАХ -3.6.1 | “Нутгийн зам төсөл”-ийг хэрэгжүүлж, 554 км хатуу хучилттай авто замыг барих ажлыг эхлүүлэх | 0 хувь | Төслийн гүйцэтгэл 30 хувьд хүрсэн байна. | 1.8 км хатуу хучилттай замын үргэлжлэл 450 м , Очир дэлгүүрийн уулзвараас Төрийн банкны уулзавар хүртэлх хатуу хучилттай замын үргэлжлэл 1.4 км замыг Сэлэнгэ АЗЗА ХХК хийж гүйцэтгэхээр шалгараад байна. Төсөвт өртөг: 920 сая төгрөг | 70 |
| **БҮЛЭГ 4.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | | | | | | |
| **Зорилго 4.1.Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.** | | | | | | |
| 4.1. 1 | МУТЖҮЧ-5.3.2, 5.3.3, ЗГҮАХ-4.1.3 | Төрийн цахим үйлчилгээний e-mongolia платформын ашиглалтыг нэмэгдүүлэх, иргэдэд танин мэдүүлэх арга хэмжээг зохион байгуулах, төрийн үйлчилгээний төрөл, тоог нэмэгдүүлж хөгжүүлэх, иргэдэд хүргэх арга хэмжээг зохион байгуулах | Төрийн 50 байгууллагын 527 үйлчилгээг нэгтгэсэн. Гар утасны аппликейшн хэлбэрээр 612031 хэрэглэгч нийт 2483598 удаа амжилттай үйлчилгээ авсан байна. | Тус системээр үйлчилгээ авч байгаа иргэдийн тоог 200000-аар нэмэгдүүлсэн байна. Төрийн болон хувийн хэвшлийн 20 байгууллагын үйлчилгээг нэгдсэн системд холбосон байна. | Төрийн үйлчилгээний нэгдсэн системд холбогдож 181 төрлийн лавлагаа мэдээллийг иргэдэд олгож байна. 2022 оны эхний хагас жилд 321 иргэн оператороор дамжуулан лавлагаа, мэдээлэл авсан байна. | 100 |
| 4.1. 4 | МУТЖҮЧ-7.4, ЗГҮАХ-4.1.1 | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газартай хамтран хаягийн нэгдсэн мэдээллийн санд холбох | Иргэний үнэмлэх 20 хувь, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ 20 хувь, эд хөрөнгийн гэрчилгээ 20 хувь холбогдсон. | | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газартай хамтран хаягийн нэгдсэн мэдээллийн санд холбосон. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4.1.8 | МУТЖҮЧ-5.3.3, ЗГҮАХ-4.1.3 | Иргэдэд тоон гарын үсэг олгож, цахим харилцаанд оролцох боломжийг бүрдүүлэх | Эхний ээлжид тоон гарын үсэг олгох нэн шаардлагатай нийт 170.0 мянган иргэн байгаагаас 23.0 мянган иргэн ашиглаж байна. | Шинээр 22.0 мянган иргэнд тоон гарын үсэг олгосон байна. | Цахим хөгжлийн багц хууль буюу Цахим гарын үсгийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хуулиуд нь 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан бөгөөд 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх болсноор суманд 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн олгож эхлэлээ. Сумын 280 иргэнд тоон гарын үсгийг олгоод байна. | 30 |
| **Зорилго 4.3.Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.** | | | | | | |
| 4.3.17 | МУТЖҮЧ-7.4.1, ЗГҮАХ-4.3.2 | Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх /Улаанбаатар хот, орон нутгийн бүх камер/ | 5 цэг | 60 цэг | Сумын төв 2, 3 дугаар багийн нийтийн эзэмшлийн зам, талбайд нийт 10 байршилд, 16 камерыг суурилуулсан. | 100 |
| **Зорилго 4.4.Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, шударга ёс, хуульт ёсыг бэхжүүлнэ.** | | | | | | |
| 4.4.1 | 5.2.19, МУТЖҮЧ-5.1.1, ЗГҮАХ -4.4.10 | Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын ажлыг зохион байгуулж, төрийн өмчид бүртгэл хийж, хяналт тавих | 2016 онд улсын үзлэг, тооллого зохион байгуулсан. | Улсын үзлэг, тооллого зохион байгуулсан байна. | Сумын Засаг даргын А/63 тоот захирамжаар 17 хүний бүрэлдэхүүнтэй төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдаж, төсөвт байгууллагуудын тооллогын явцад хяналт тавьж аргазүйн зөвлөгөөгөөр ханган төрийн | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | болон орон нутгийн өмчит байгууллагууд байгууллагын эзэмшил ашиглалтад байгаа эд хөрөнгийг тооллогод 05 сарын 02-ны өдрөөс 06 сарын 10-ны хооронд бүрэн хамруулж дууссан. Байгууллагуудын узлэг тооллогын баримтыг аймгийн ажлын хэсэгт хүлээлгэж өгөх бэлтгэл ажил хангагдсан. | |
| **Бүлэг 5.Ногоон хөгжлийн бодлого** | | | | | | |
| **Зорилго 5.1.Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | |
| 5.1.9 | МУТЖҮЧ-6.2.5, ЗГҮАХ-5.1.5 | Ойжуулалт, нөхөн сэргээлтийг чанаржуулан, ойн хомстол, доройтлыг бууруулж, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлэх | 4.0 мянган га талбайг ойжуулж,<br>65.8 мянган га талбайд хөнөөлт шавжны өвчний тэмцлийг хийсэн.<br>Ойн түймэрт өртсөн талбай 400.0 мянган га байна.<br>Ой зохион байгуулалтыг 1169.0 мянган га, ойн цэвэрлэгээг<br>32.0 мянган га талбайд хийсэн. | 8.0 мянган га талбайг ойжуулж, нөхөн сэргээсэн байна. Ойн хөнөөлт, шавж өвчний голомттой 200.0 мянган га талбайд тэмцлийн ажил явуулсан байна. Шатсан ойн талбайг өмнөх жилийнхээс 5 хувиар бууруулна. Ой зохион байгуулалтыг 1,600.0 мянган га-д явуулсан байна. 34.0 мянган га талбайн ойд арчилгаа, цэвэрлэгээ хийсэн байна. | 1. Шинэбадрах ХХК нь, Бүтээлийн нуур ХХК нь Хүрмэн ой ХХК-иар ойжуулалтын ажлыг гүйцэтгүүлсэн.<br>Бүтээлийн нуур ХХК Сангалтайд 20 га талбайд шинэс модны суулгацаар,<br>Шинэ бадрах ХХК Гүн шүрэнд 20 га талбайд шинэс модны суулгацаар хийсэн. Ойжуулалтын ажлыг байгаль хамгаалагч Ц. Мөнхтөр, сум дундын ойн ангитай хамтран гүйцэтгэлийг шалгалаа.<br>2. Сумын хэмжээнд Иргэд гоёлын мод-21 ширхэг, жимсний мод-32 ширхгийг, ААНБайгууллага гоёлын мод-82 ширхэг, жимсний мод-68 ширхгийг тарьсан байна. Нийт шилмүүст мод-188 ширхэг, гоёлын мод-103 | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ширхэг, жимсний мод-100 ширхгийг тарьсан байна.<br>3.2021 оны намрын судалгаагаар Бургасны бүгэгт Тамгын хоолойгоос Шүрэн хүртэл 1000 га талбайд хийж гүйцэтгэж саналыг аймгийн БОАЖГазарт хүргүүлсэн. | |
| 5.1.15 | МУТЖҮЧ-6.4.2, 6.4.4, ЗГҮАХ-5.1.12 | Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг эрчим хүч, хөдөө аж ахуй, барилга, тээвэр, аж үйлдвэр, хог хаягдлын салбарт хэрэгжүүлэх | Хүлэмжийн хийн ялгарлын 2010 оны суурь түвшин 25815.3 мян.т CO2 экв. | Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэх 2022 оны арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг 80 хувьд хүргэсэн байна. | 1.Хогийн нэгдсэн цэгт иргэд хогоо асгах зам талбай гаргах, түрж овоолго хийх, булшлах зэрэг ажлыг Бүтээлийн нуур ХХК-тай 1 жилийн хугацаатай гэрээ хийж гүйцэтгэлд нь хяналт тавин ажиллаж байна.<br>2.2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн Сумын Засаг даргын А/37 тоот “Бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах тухай” захирамжын дагуу 2022 оны 03 дугаар сарын 24-нөөс 26-ны өдрүүдэд зохион байгуулан 160 иргэн хог цэвэрлэгээнд оролцож ойр орчмынхоо 50м болон сумын төв доторх 1,3 км засмал замыг цэвэрлэж нийт 4 тн хогийг хогийн нэгдсэн цэгт буулгасан. | 70 |

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮНГИЙН НЭГТГЭЛ**

2022.06.15
Цагааннуур сум

| Зорилт арга хэмжээ | Заалт | 2022 он /хувь | | | | | Дүн /%/ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 0 | 30 | 50 | 70 | 100 | |
| **БҮЛЭГ 2.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| Зорилго 2.1 | 12 | | 2 | 7 | 3 | | 51,6% |
| Зорилго 2.2. | 11 | | | | 4 | 7 | 89,0% |
| Зорилго 2.5 | 8 | | 1 | 4 | 1 | 2 | 62,5% |
| Дүн | 31 | | 3 | 11 | 8 | 9 | 67,7% |
| **БҮЛЭГ 3.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| Зорилго 3.3. | 4 | | | 3 | | 1 | 62,5% |
| Зорилго 3.6 | 1 | | | | 1 | | 70% |
| Дүн | 5 | | | 3 | 1 | 1 | 66,2% |
| **БҮЛЭГ 4.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | | | | | | | |
| Зорилго 4.1 | 3 | | 1 | | | 2 | 76,6% |
| Зорилго 4.3 | 1 | | | | | 1 | 100% |
| Зорилго 4.4. | 1 | | | | | 1 | 100% |
| Дүн | 5 | | 1 | | | 4 | 92,2 |
| **БҮЛЭГ 5.НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| Зорилго 5.1. | 2 | | | | 1 | 1 | 85% |
| Дүн | 2 | | | | 1 | 1 | 85% |
| **Нийт дүн** | **43** | **0** | **4** | **14** | **10** | **15** | **77,7%** |